Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

ГАЗРЫН БИРЖИЙН
ЦАХИМ СИСТЕМ




# ГАЗРЫН БИРЖИЙГ ЦАХИМ СИСТЕМИЙН ХЭРЭГЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

2020 он

# 12.ДУУДЛАГА ХУДАЛДААНД ОРОЛЦОХ ХҮСЭЛТ

Дуудлага худалдааны зар нь “Танхимаар” болон “Цахимаар” гэсэн 2 төрлөөр зарлагддаг бөгөөд цахимаар явагдах дуудлага худалдаа бол хэрэглэгч шууд заагдсан дансанд хураамж болон дэнчинг тушааж оролцох хүсэлтээ илгээж болно.






Хэрэв системд нэвтрээгүй бол энэ хэсэг харагдах бөгөөд системд бүртгүүлсэн хэрэглэгч нэвтэрсний дараа дуудлага худалдаанд цахимаар оролцох боломжтой.




Хураамж болон дэнчинг тус тусад нь дансанд тушаах бөгөөд тушаасан баримтын зургийг авч оролцох хүсэлтдээ хавсралтаар оруулах шаардлагатай.

Оролцох хүсэлт амжилттай илгээгдсэн бол энэхүү мессеж харагдах болно.

Системийн админаас таны төлбөр төлөгдсөн эсэхийг шалгасны дараа таны хүсэлтийг баталгаажуулах эсвэл татгалзах бөгөөд энэ талаар таньд гар утсанд мессежээр болон имэйлээр мэдэгдэнэ.



Хэрэглэгч өөрийн илгээсэн бүх хүсэлтүүдийг дараах байдлаар харах боломжтой.






Оролцох хүсэлтийг татгалзсан бол хэрэглэгчид энэхүү мессеж харагдах бөгөөд тухайн дуудлага худалдааны оролцогч бүртгэх хугацаа дуусахаас өмнө дахин оролцох хүсэлтийн мэдээллүүдийг үнэн зөв оруулаад хүсэлт илгээх боломжтой.




Оролцох хүсэлтийг зөвшөөрсөн бхол хэрэглэгчид энэхүү мессеж харагдах бөгөөд дуудлага худалдааны үнийн санал авах өдөр системд нэвтэрч өөрийн үнийн саналаа 15 цагаас өмнө өгөх боломжтой.

# 13.ДУУДЛАГА ХУДАЛДААНД ҮНИЙН САНАЛ

Дуудлага худалдааны зарын дэлгэрэнгүй хуудас дахь доорхи хугацаанд л оролцогчоор бүртгүүлэх болон үнийн саналаа өгөх боломжтой тул эдгээр огноонуудыг анхааралтай шалгана уу.

| | |
|---|---|
| Оролцогч бүртгэх хугацаа | 2019-07-29 00:00:00 / 2019-08-01 08:30:00 |
| Үнийн санал авах хугацаа | 2019-08-01 09:00:00 / 2019-08-01 15:00:00 |

Доорхи үнийн санал өгөх товчийг дарснаар үнийн санал өгөх хуудас руу шилжинэ.



Үнийн санал өгөхөөс өмнө дараах мэдэгдэл гарч ирэх бөгөөд уншиж танилцсаны дараа “Зөвшөөрч байна” дээр дарснаар мэдэгдэл алга болно.



Доорхи зурагт нэг хэрэглэгч нэг өдөр явагдаж буй 2 дуудлага худалдаанд оролцож буй тохиолдолд үнийн санал өгөх хуудас харагдаж байна.






Бүх дуудлага худалдаа тухайн өдрийн 15 цагт дуусах бөгөөд 15 цаг хүртэл хэдэн цаг, минут, секунд үлдсэн байгаар харуулна.




Дуудлага худалдааны хүрээ ямар өнгөтэй байгаагаас та тухайн дуудлага худалдаанд үнийн саналаар ялж байгаа эсвэл ялагдаж байгааг ялгаж харж болно.




Дуудлага худалдааны анхны үнээс хамаарч үнэ өсгөх доод болон дээд хязгаар системээс автоматаар тооцологдох бөгөөд хэрэглэгч доод эсвэл дээд хязгаараар үнийн саналаа өсгөн илгээх боломжтой.

Үнийн саналыг 15 цагаас хойш хүлээлтийн 60 секундэд өгвөл дахин 60 секунд сунгагдана. Хүлээлтийн 60 секундэд үнийн санал ирэхгүй бол дуудлага худалдаа автоматаар хаагдаж хамгийн сүүлд үнийн санал ирүүлсэн хэрэглэгч ялагч болно.



15 цагаас эхлэн үндсэн цаг дуусч сүүлийн 1 минут тоологдож эхэлсэн бол доорх шар бичиг харагдана. Аль нэгэн оролцогч үнийн санал илгээвэл дахин 60 секунд доош нь тоолно. Таны интернэтийн хурдаас хамаарч үнийн санал илгээхэд хэдэн секунд хүлээгдэх магадлалтай тул сүүлийн 5 секундэд илгээсэн санал амжихгүй байх магадлалтайг сануулъя. Амжиж үнийн саналаа илгээхгүй бол дуудлага худалдаа автоматаар хаагдаж дуусах тул анхааралтай оролцоно уу!



Хамгийн дээр байгаа үнийн санал нь хамгийн сүүлд ирсэн үнийн санал болно.

Доорхи зурагт тухайн дуудлага худалдаанд нэвтэрсэн хэрэглэгч ялж буй учраас ногоон хүрээтэй, харин ялагдаж буй дуудлага худалдаа улаан хүрээтэй харагдаж байна.






1. Үнийн санал өгөх доод хязгаараар үнийн санал өгөх товч
2. Үнийн санал өгөх дээд хязгаараар үнийн санал өгөх товч
3. Санал амжилттай илгээгдсэн үед харагдах мессеж
4. Санал илгээгдээгүй буюу амжилтгүй үед харагдах мессеж



# 14. ОРОЛЦСОН ДУУДЛАГА ХУДАЛДАА

Нэвтэрснийд дараа хувийн мэдээлэл хуудас руу орно.



Хэрэглэгч өөрийн эрхээр нэвтэрсний дараа өөрийн оролцсон дуудлага худалдааны дэлгэрэнгүй хуудас руу ороход дуудлага худалдаанд ирсэн үнийн саналууд харагдах бөгөөд хамгийн сүүлд ирсэн үнийн санал хамгийн дээрээ харагдана.






Хэрэв тухайн дуудлага худалдаанд та хамгийн сүүлийн үнийг илгээсэн буюу ялагч болсон бол дараах дэлгэц харагдана.

Дуудлага худалдааны журмын дагуу ялагч болсон хэрэглэгч 7 хоногийн дотор дуудлага худалдааг зохион байгуулсан эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулна. Гэрээ байгуулсан өдрөөс 14 хоногийн дотор дуудлага худалдааны үнийг бүрэн төлснөөр эрх шилжинэ.

Хэрэв заасан хугацаанд үнийг төлөөгүй тохиолдолд тухайн хэрэглэгчийн дэнчинг буцаан олгохгүй бөгөөд тухайн дуудлага худалдаа хүчингүй болно.

Ялагчаас бусад оролцогчийн дэнчинг дуудлага худалдаа болсон өдрөөс хойш ажлын 5 хоногт буцаан шилжүүлнэ.

# 15. СҮҮЛИЙН ҮНИЙН САНАЛУУД ХАРАХ




Хэрэглэгчээр нэвтэрсэн эсэхээс үл хамаарч бүх зарлагдсан дуудлага худалдаанд ирсэн үнийн санал олон нийтэд нээлттэй.

Системийн нүүр хуудасны доорх хэсэгт сүүлд ирсэн үнийн саналууд харагдах бөгөөд “Бүгд” дээр дарснаар цааш дэлгэрэнгүй харах хуудас руу шилжинэ.

Танхимаар болон цахимаар явагдсан бүх дуудлага худалдаанд ирсэн үнийн саналыг харах боломжтой.




1. #2020-1840 ДУГААРТАЙ ДУУДЛАГА ХУДАЛДАА - БАЯНХОНГОР, БАЯН-ОВОО, 4-Р БАГ

| Д/д | Хэрэглэгч | | Үнэ |
|---|---|---|---|
| 1 | Хэрэглэгч: 477 | 14:42:05 | 950,000₮ |
| 2 | Хэрэглэгч: 4776 | 13:38:09 | 850,000₮ |
| 3 | Хэрэглэгч: 4777 | 2020-01-22 13:38:01 | 750,000₮ |
| 4 | Хэрэглэгч: 4776 | 2020-01-22 13:37:22 | 650,000₮ |
| 5 | Хэрэглэгч: 4777 | 2020-01-22 11:13:37 | 600,000₮ |

2. #2019-1824 ДУГААРТАЙ ДУУДЛАГА ХУДАЛДАА - СЭЛЭНГЭ, СҮХБААТАР, 8-Р БАГ

| Д/д | Хэрэглэгч | Огноо | Үнэ |
|---|---|---|---|
| 1 | Хэрэглэгч: 4772 | 2019-11-25 18:54:02 | 6,900,000₮ |
| 2 | Хэрэглэгч: 4774 | 2019-11-25 18:53:50 | 6,400,000₮ |
| 3 | Хэрэглэгч: 4772 | 2019-11-25 18:53:48 | 5,900,000₮ |
| 4 | Хэрэглэгч: 4774 | 2019-11-25 18:51:59 | 5,400,000₮ |
| 5 | Хэрэглэгч: 4772 | 2019-11-25 18:45:37 | 4,900,000₮ |

3. #2019-1796 ДУГААРТАЙ ДУУДЛАГА ХУДАЛДАА - УЛААНБААТАР, БАЯНЗҮРХ, 11-Р ХОРОО

| Д/д | Хэрэглэгч | Огноо | Үнэ |
|---|---|---|---|
| 1 | Хэрэглэгч: 4773 | 2019-11-25 18:45:13 | 25,500,000₮ |
| 2 | Хэрэглэгч: 4763 | 2019-11-12 16:39:29 | 25,000,000₮ |
| 3 | Хэрэглэгч: 4764 | 2019-11-12 16:38:52 | 24,000,000₮ |
| 4 | Хэрэглэгч: 4763 | 2019-11-12 16:38:23 | 23,000,000₮ |
| 5 | Хэрэглэгч: 4764 | 2019-11-12 16:38:16 | 22,000,000₮ |

4. #2019-1837 ДУГААРТАЙ ДУУДЛАГА ХУДАЛДАА - УЛААНБААТАР, СҮХБААТАР, 8-Р ХОРОО

| Д/д | Хэрэглэгч | Огноо | Үнэ |
|---|---|---|---|
| 1 | Хэрэглэгч: 4766 | 2019-11-12 17:22:03 | 2,850,000,000₮ |
| 2 | Хэрэглэгч: 4767 | 2019-11-12 17:21:46 | 2,750,000,000₮ |
| 3 | Хэрэглэгч: 4766 | 2019-11-12 17:21:33 | 2,650,000,000₮ |
| 4 | Хэрэглэгч: 4769 | 2019-11-12 17:21:32 | 2,550,000,000₮ |
| 5 | Хэрэглэгч: 4766 | 2019-11-12 17:21:04 | 2,500,000,000₮ |